

ХӨДӨЛМӨРИЙН ХӨЛС, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ОРЛОГООС ДАРААХ ХУВЬ ХЭМЖЭЭГЭЭР ТӨЛНӨ

Ажил олгогчийн төлөх шимтгэлийн хувь хэмжээ	0.8%; 1.8%; 2.8%
---	------------------

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ДААТГАЛ

Даатгуулагчид олгох тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн нөхцөл:

Дараах нөхцөл байдалд гарсан үйлдвэрлэлийн осолд даатгуулагч өртсөн тохиолдолд тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгоно. Үүнд:

- Ажлын байрандаа болон бусад газарт ажил үүргээ гүйцэтгэх явцад
- Ажил эхлэхийн өмнө ажилд бэлтгэх буюу дууссаны дараа ажлын байр, багаж хэрэгслээ эмхэлж цэгцлэх үед
- Ажилдаа ирэх, буцах замд

Даатгуулагчийн шимтгэл төлсөн байвал зохих хугацаа:

Даатгуулагч үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа байнга буюу удаан хугацаагаар алдвал түүнд шимтгэл төлж ажилласан хугацааг үл харгалзан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгоно.

Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг тогтоох:

Даатгуулагчийн үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдсан шалтгаан, хувь, хэмжээ, хугацааг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн дэргэдэх Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комисс тогтооно.

ҮОМШӨ-ний Тахир дутуугийн тэтгэвэр



“Тахир дутуугийн тэтгэвэр” гэж үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан даатгуулагчид тэтгэврийн даатгалын шимтгэл төлж ажилласан хугацааны хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос хамааралтайгаар тэтгэврийн даатгалын сангаас түүний хөдөлмөрийн чадваргүй байх хугацаанд буюу хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл хугацаанд олгож байгаа мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Тахир дутуугийн тэтгэвэр авах эрх:

Даатгуулагч үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа удаан хугацаагаар буюу байнга алдсан бол тахир дутуугийн тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй.

Тахир дутуугийн тэтгэврийн хэмжээ:

Тахир дутуугийн тэтгэврийг даатгуулагчийн сарын дундаж хөдөлмөрийн хөлс, орлогоос үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа 10

хүртэл хувиар алдсан бол 10 хувиар, 10-аас дээш хувиар алдсан бол хөдөлмөрийн чадвар алдалтын хувиар тогтооно.

Тэтгэвэр тогтоолгосон боловч 12 сараас доошгүй хугацаанд ажил, хөдөлмөр эрхэлж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн даатгуулагчийн авч байгаа тэтгэврийн хэмжээг анхны тэтгэвэр тогтоолгосон дундаж цалингаас 12 сар тутамд 1.5 хувиар бодож нэмэгдүүлэн тогтооно.

Жишээ: Даатгуулагч нийгмийн даатгалын шимтгэлийг 2 жил төлж ажиллаж байгаад мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа 50%-иар алдсан, түүний дундаж цалин нь 1 000 000 төгрөг гэвэл:

-Сард олговол зохих тэтгэвэр:

$1,000,000\text{₮} * 50\% (\text{ХЧАлдалтын хувь}) = 500,000\text{₮}$

ҮОМШӨ-ний Тэжээгчээ алдсаны тэтгэвэр



“Тэжээгчээ алдсаны тэтгэвэр” гэж үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас нас барсан даатгуулагчийн асрамжид байсан хөдөлмөрийн чадваргүй гишүүдэд тэтгэврийн даатгалын сангаас олгож байгаа мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Тэжээгчээ алдсаны тэтгэвэр авах эрх:

Үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас даатгуулагч нас барсан тохиолдолд түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд нь тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй.

Тэжээгчээ алдсаны тэтгэврийн хэмжээ:

Тэжээгчээ алдсаны тэтгэврийг нас барсан даатгуулагчийн авч байсан дундаж хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос доор дурдсан хувь хэмжээгээр тогтооно:

- хөдөлмөрийн чадваргүй 3, түүнээс дээш хүнтэй бол 100 хувь;
- хөдөлмөрийн чадваргүй 2 хүнтэй бол 75 хувь;
- хөдөлмөрийн чадваргүй 1 хүнтэй бол 50 хувь.

ҮОМШӨ-ний даатгалын сангаас олгох хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэм

ҮОМШӨ-ний даатгалын сангаас олгох хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж:

Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах эрх:

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа түр алдсан даатгуулагч хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах эрхтэй.

Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийн хэмжээ:

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдсан даатгуулагчид хөдөлмөрийн чадвар түр алдсаны

тэтгэмжийг шимтгэл төлж ажилласан хугацааг үл харгалзан хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 100 хувиар бодож олгоно.

Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг ажлын өдрөөр тооцно.

Хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр:

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан даатгуулагчид хиймэл эрхтэн, засал эмчилгээ хийлгэсний үнийг эхний удаа 100 хувь, 2 дахь удаад үнийн 50 хувийг олгоно. Мөн зайлшгүй шаардлагаар мэргэжлийн (гэмтлийн) эмнэлгийн байгууллагын дүгнэлтийн дагуу засал эмчилгээ (протез, ортопед)-г гадаад оронд хийлгэхэд түүний нэг удаагийн үнийг олгоно.

Гадаад оронд хийлгэсэн протез, ортопедийн төлбөрийг Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан тушаалаар баталсан жишиг үнийн жагсаалтыг баримтлан бэлэн бусаар төлнө.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан даатгуулагч рашаан сувилалд сувилуулах зардал:

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас тахир дутуу болсон даатгуулагчийг сувиллах сувиллын газрын тусламж үйлчилгээний хувьсах зардлын хэмжээ Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 16 дугаар тогтоолоор нэг хоногт 60 000 төгрөг байна.

Тэтгэврийн даатгалын шимтгэл:

Даатгуулагчийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас тахир дутуугийн тэтгэвэр авах хугацааны тэтгэврийн даатгалын шимтгэлийг тус сангаас тэтгэврийн даатгалын санд жил бүр төлнө.

Бүрдүүлэх баримт бичиг:

- Нийгмийн даатгалын дэвтэр (2021 оноос өмнөх);
- Хөдөлмөрийн дэвтэр (1995 оноос өмнөх);
- Хөдөлмөрийн хөлсний тодорхойлолт (1995 оноос өмнө ажилласан хугацаанд авсан хөдөлмөрийн хөлснөөс тэтгэвэр тогтоолгох бол);
- Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тогтоосон Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын акт;
- Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэсэн акт;
- Иргэний үнэмлэхний хуулбар, эсхүл лавлагаа